



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 27

Эрдэнэт

Түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай

"Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 4.1-ийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүгэрсүрэн овогтой Эрдэнэцэцэгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн тус албан тушаалд шинээр ажилтан томилогдох хүртэл хугацаанд томилсугай.

2. Баттулга овогтой Золоог аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үүргээс 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөр чөлөөлсүгэй.

3. Д.Эрдэнэцэцэгт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацаанд сарын цалинг ТЗ-11 ангилал, зэрэглэлийн V шатлалд багтаан 913787 төгрөгөөр тогтоон сар бүр тооцож олгохыг нягтлан бодогч Б.Золоод зөвшөөрсүгэй.

4. Д.Эрдэнэцэцэгтэй ажил хүлээлцэх комиссыг хавсралтын ёсоор баталсугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА